



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2014 оны 05 сарын 21 өдөр

Дугаар 145

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 38.10, 63.1.2, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 14.5, 14.8, 14.11, 18.1, 19.3 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Хамтын хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах, хамтын хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох тухай журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Энэхүү журмыг 2014 оны 6 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

3. Энэ журам мөрдөгдөж эхлэх өдрөөс Үнэт цаасны хороо /хуучнаар/-ны 2003 оны 46 дугаар тогтоолоор батлагдсан “Хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааг зохицуулах тухай журам”-ыг хүчингүй болсонд тооцсугай.


4. Журмын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

000173



**ХАМТЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГ ҮҮСГЭН БАЙГУУЛАХ,
ХАМТЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ТУХАЙ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь хамтын хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах, хамтын хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг Санхүүгийн зохицуулах хороо /цаашид “Хороо” гэх/-ноос олгохтой холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2. Энэхүү журамд заасан хамтын хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох болон хамтын хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах бичиг баримт, түүний нэгж эрхийн танилцуулыг Хороонд бүртгэхтэй холбоотой харилцаанаас бусад харилцаанд хамаарахгүй.

1.3. Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан зохицуулалттай этгээдэд хамаарах гадаад улсад бүртгэлтэй хөрөнгө оруулалтын менежментийн компани, кастодиан болон бусад хуулийн этгээд, мэргэжилтний зүгээс Монгол Улсад хамтын хөрөнгө оруулалтын сан үүсгэн байгуулах ажиллагааг Хороонд бүртгүүлсний үндсэн дээр эрхлэх ба уг бүртгэлийг гүйцэтгэхтэй холбоотой харилцааг бие даасан журмаар зохицуулна.

1.4. Гадаад улсад бүртгэлтэй хамтын болон хувийн хөрөнгө оруулалтын сан Монгол Улсад үйл ажиллагаа явуулахтай холбоотой харилцааг бие даасан журмаар зохицуулна.

1.5. Хамтын хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах ажиллагааг Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 14.4, 14.9-д заасан дараалалд үндэслэн дор дурдсан дарааллаар гүйцэтгэнэ:

1.5.1. хамтын хөрөнгө оруулалтын сан үүсгэн байгуулах баримт бичгийг Хороонд бүртгүүлэх;

1.5.2. хамтын хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах баримт бичгийг Хороонд бүртгүүлсний үндсэн дээр хамтын хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах хурлыг зарлан хуралдуулах, үүсгэн байгуулах шийдвэр гарган, сангийн дүрмийг батлах, эрх бүхий албан тушаалтныг томилох;

1.5.3. хамтын хөрөнгө оруулалтын санг хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлэх;

1.5.4. хөрөнгө оруулалтын менежментийн үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой хөрөнгө итгэмжлэн удирдах үйлчилгээний гэрээг байгуулах;

1.5.5. хамтын хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгийг хадгалахтай холбоотой хөрөнгө хадгалах үйлчилгээний гэрээг байгуулах;

1.5.6. хамтын хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн танилцуулгыг боловсруулж дуусгах, уг танилцуулгыг Хороонд бүртгүүлэх;

1.5.7. хамтын хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн танилцуулгыг нийтэд танилцуулах, нийтээс хөрөнгө төвлөрүүлэх;

1.5.8. хамтын хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авах, уг сангийн үйл ажиллагааг эхлүүлэх.

1.6. Хамтын хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах ажиллагааг гагцхүү хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээд эрхлэн гүйцэтгэнэ. /цаашид “үүсгэн байгуулагч хөрөнгө оруулалтын менежментийн компани” гэх/

1.7. Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 14.10-т заасны дагуу энэхүү журмын 1.5-д заасан үйл ажиллагаа бүрэн хийгдэж, хамтын хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосныг хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлснээр хамтын хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулагдсанд тооцно.

1.8. Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 14.14-т заасны дагуу хамтын хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхлэх эрх гагцхүү Хорооноос хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон өдөр үүсэх бөгөөд уг хуулийн 14.9.1 болон энэхүү журмын 1.5.3-д заасны дагуу тухайн хамтын хөрөнгө оруулалтын санг хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгэх нь хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа явуулах эрх олгосон гэж үзэх үндэслэл болохгүй.

1.9. Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 14.15-д заасны дагуу хамтын хөрөнгө оруулалтын сан хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгэгдэх хүртэлх үүсгэн байгуулахтай холбоотой ажиллагааг тухайн хөрөнгө оруулалтын санг төлөөлж үүсгэн байгуулагч хөрөнгө оруулалтын менежментийн компани, түүний томилсон эрх бүхий албан тушаалтан гүйцэтгэх ба хамтын хөрөнгө оруулалтын санг хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгэснээс хойших ажиллагааг тухайн хамтын хөрөнгө оруулалтын сангийн эрх бүхий албан тушаалтан гүйцэтгэнэ.

1.10. Хамтын хөрөнгө оруулалтын сангийн бусдаас татан төвлөрүүлэх хөрөнгийн доод хэмжээ 1 /нэг/ тэрбум төгрөг байна.

1.11. Хамтын хөрөнгө оруулалтын сангийн төлөөлөн удирдах зөвлөл нь 5 буюу түүнээс дээш гишүүнтэй байх ба тэдгээрийн гуравны нэгээс доошгүй нь Компанийн тухай хууль болон дүрмээр тогтоосон шаардлага хангасан хараат бус гишүүн байна.

Хоёр. Хамтын хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах баримт бичгийг бүртгүүлэх

2.1. Үүсгэн байгуулагч хөрөнгө оруулалтын менежментийн компани нь хамтын хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах ажиллагааг дараах хэлбэрийн аль нэгээр зохион байгуулж болно:

2.1.1. хамтын хөрөнгө оруулалтын санг дангаар үүсгэн байгуулах;

2.1.2. хамтын хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах эрх бүхий өөр бусад хөрөнгө оруулалтын менежментийн компанитай гэрээний үндсэн дээр хамтран үүсгэн байгуулах.

2.2. Үүсгэн байгуулагч хөрөнгө оруулалтын менежментийн компани нь хэд хэдэн хөрөнгө оруулалтын сан үүсгэн байгуулж болох бөгөөд тухай бүр хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах нөхцөл, шаардлага, шалгуурыг хангасан байна.

2.3. Хамтын хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах ажиллагааг эхлүүлэхээс өмнө үүсгэн байгуулагч хөрөнгө оруулалтын менежментийн компани дараах бэлтгэл ажлыг гүйцэтгэнэ:

2.3.1. үүсгэн байгуулах хамтын хөрөнгө оруулалтын сангийн үүсгэн байгуулах шийдвэр, дүрэм, багц журмын болон хөрөнгө оруулалтын бодлогын бичиг баримтын төслүүдийг боловсруулах;

2.3.2. үүсгэн байгуулах хамтын хөрөнгө оруулалтын сангийн хуулийн этгээдийн оноосон нэрийг сонгох, нэрийг баталгаажуулах;

2.3.3. үүсгэн байгуулах хамтын хөрөнгө оруулалтын сан бусдаас хөрөнгө итгэмжлэн удирдах болон хөрөнгө хадгалах үйлчилгээ авахтай холбоотой гэрээ, хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийг бусдад худалдахтай холбоотой гэрээний төслийг боловсруулах, холбогдох хэлэлцээрийг см гэрээний төслийг эцэслэн байгуулах бэлтгэлийг хангах;

2.3.4. үүсгэн байгуулах хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтын бодлогыг тодорхойлоход шаардлагатай судалгааг гүйцэтгэх, судалгааны үр дүнд үндэслэн холбогдох тооцооллыг гүйцэтгэх, хөрөнгө оруулалтын бодлогын бичиг баримтын төслийг боловсруулах;

2.3.5. үүсгэн байгуулах хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаанд холбоотой хууль, дүрэм, журмаар тогтоосон нөхцөл, шаардлагыг хангаж байгаа эсэх, санг үүсгэн байгуулсны дараа тэдгээрийг хангаж ажиллах боломжтой эсэхийг нягтлах, энэ талаар холбогдох нотлох баримт, дүгнэлтийг бэлтгэх.

2.4. Хамтын хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах бэлтгэлийг хангах явцад үүсгэн байгуулагч хөрөнгө оруулалтын менежментийн компани дараах ажиллагааг гүйцэтгэхийг хориглоно:

2.4.1. хамтын хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах бичиг баримтыг Хороонд бүртгүүлэхгүйгээр хамтын хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах хурал зарлах;

2.4.2. хамтын хөрөнгө оруулалтын сангийн танилцуулгыг Хороонд бүртгүүлэх хүртэлх хугацаанд үүсгэн байгуулахаар ажиллаж байгаа хамтын хөрөнгө оруулалтын сангийн талаар нийтэд сурталчлах, танилцуулах;

2.4.3. хамтын хөрөнгө оруулалтын сангийн танилцуулгыг Хороонд бүртгүүлэх хүртэлх хугацаанд аливаа хэлбэрээр үүсгэн байгуулах хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийг бусдад худалдах, эсхүл худалдахаар гэрээ байгуулах болон аливаа бусад хэлбэрээр бусдаас хөрөнгө татан төвлөрүүлэх.

2.5. Хамтын хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах бичиг баримтыг Хороонд бүртгүүлэх хүсэлтэд доор дурдсан мэдээллийг тусгана:

2.5.1. тухайн хамтын хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах ажиллагааг үүсгэн байгуулагч менежментийн компани нь гүйцэтгэх тухай шийдвэрийн талаарх мэдээлэл;

2.5.2. үүсгэн байгуулахаар төлөвлөж байгаа хамтын хөрөнгө оруулалтын сангийн төрөл;

2.5.3. үүсгэн байгуулахаар төлөвлөж байгаа хамтын хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах ажиллагааг гүйцэтгэх хугацааны талаарх төлөвлөгөө /уг ажиллагааны нийт үргэлжлэх хугацаа нь Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 19.5-д заасан хугацаанаас ихгүй байна/;

2.5.4. үүсгэн байгуулахаар төлөвлөж байгаа хамтын хөрөнгө оруулалтын сангийн активын хэмжээ, нийтээс татан төвлөрүүлэхээр тооцсон хөрөнгийн хэмжээ /татан төвлөрүүлэхээр тооцсон нийт акивын хэмжээ нь энэхүү журмын 1.10-т заасан хэмжээнээс багагүй байна/;

2.5.5. хамтын хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулагч хөрөнгө оруулалтын менежментийн компанийн зүгээс тухайн үүсгэн байгуулах хамтын хөрөнгө оруулалтын санд оруулах хөрөнгийн хэмжээ, уг хөрөнгийг оруулах санхүүгийн чадавхын талаарх мэдээлэл, хөрөнгө оруулалт хийх хэлбэр;

2.5.6. үүсгэн байгуулах ажиллагааны нийт төсөв, гарсан зардал болон уг зардлыг хэрхэн санхүүжүүлэх, санхүүжилтийг гаргах санхүүгийн боломж, өөрийн хөрөнгийн хүрэлцээний талаарх мэдээлэл, үүсгэн байгуулах ажиллагааны явцад гаргах зардлыг хэрхэн буцаан төлөхөөр тооцсон тухай мэдээлэл;

2.5.7. үүсгэн байгуулах бичиг баримт, судалгааг гүйцэтгэхэд оролцсон албан тушаалтан, хууль зүйн, болон бусад үйлчилгээ үзүүлсэн хуулийн этгээд, мэргэжилтний холбогдох үйлчилгээг үзүүлэх эрх бүхий болон тохиромжтой этгээд мөн болох тухай мэдээлэл, тэдгээрийн гүйцэтгэсэн ажлын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл;

2.5.8. Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 14.7.6-д заасны дагуу Хорооноос ирүүлэхээр тогтоосон бусад мэдээлэл.

2.6. Энэхүү журмын 2.5-д заасан хүсэлтэд дараах бичиг баримтыг хавсаргана:

2.6.1. хамтын хөрөнгө оруулалтын сан үүсгэн байгуулах баримт бичгийг бүртгүүлэх хүсэлтийг хянан шийдвэрлэхтэй холбоотой улсын тэмдэгтийн хураамж болон үйлчилгээний хөлсийг төлсөн баримт;

2.6.2. үүсгэн байгуулагч хөрөнгө оруулалтын менежментийн компанийн хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хуулбар, үйлчилгээ үзүүлж байгаа бусад хөрөнгө оруулалтын сан, хуулийн этгээдийн талаарх мэдээлэл;

2.6.3. үүсгэн байгуулах бичиг баримтын төсөл болох үүсгэн байгуулах гэрээ, үүсгэн байгуулах шийдвэр, дүрмийн төсөл;

2.6.4. хамтын хөрөнгө оруулалтын сангийн багц журмын төсөл болон хөрөнгө итгэмжлэн удирдах журмын төсөл, эрсдлийн удирдлагын журмын төсөл, хяналтын үйл ажиллагааны журмын төсөл, татан буулгах ажиллагааны зэрэг журмын төслүүд;

2.6.5. үүсгэн байгуулах хамтын хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгө оруулалтын бодлогын бичиг баримтын төсөл (үүнд хөрөнгө оруулалтын болон зээлтэй холбоотой эрх мэдлийн хуваарилалтын талаар тусгасан байна);

2.6.6. хөрөнгө оруулалтын менежментийн компанитай байгуулах хөрөнгө итгэмжлэн удирдах үйлчилгээний гэрээний төсөл;

2.6.7. кастодиантай байгуулах хөрөнгө хадгалах үйлчилгээний гэрээний төсөл;

2.6.8. хамтын хөрөнгө оруулалтын санг нэгээс дээш тооны хөрөнгө оруулалтын менежментийн компани хамтран үүсгэн байгуулж байгаа бол тэдгээрийн хооронд байгуулсан Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 14.2-г заасан гэрээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;

2.6.9. үүсгэн байгуулагч хөрөнгө оруулалтын менежментийн компанийн дүрмийн нотариатаар баталгаажуулсан хүчин төгөлдөр хуулбар;

2.6.10. Үүсгэн байгуулах хамтын хөрөнгө оруулалтын сантай хөрөнгө итгэмжлэн удирдах үйлчилгээний гэрээ байгуулах хөрөнгө оруулалтын менежментийн компани нь үүсгэн байгуулагч хөрөнгө оруулалтын менежментийн компаниас өөр хуулийн этгээд бол уг гэрээ байгуулах хуулийн этгээдийн дүрмийн нотариатаар баталгаажуулсан хуулбар;

2.6.11. үүсгэн байгуулах хамтын хөрөнгө оруулалтын сангийн бизнес төлөвлөгөөний төсөл, уг төлөвлөгөөг боловсруулсан судалгааны тайлан;

2.6.12. кастодианы үйлчилгээг нэг этгээдээс авах тухай тодорхойлолт;

2.6.13. үүсгэн байгуулагч хөрөнгө оруулалтын менежментийн компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд болон үүсгэн байгуулах ажиллагааг гүйцэтгэж байгаа албан тушаалтан нь тохиромжтой этгээд мөн болох болон тэдгээрийн ур чадвар, туршлагын талаарх дэлгэрэнгүй тодохойлолт;

2.6.14. хөрөнгө оруулалтын менежментийн компанийн зүгээс хамтын хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах ажиллагааг хоёроос доошгүй тооны мэргэжилтэн хариуцан ажиллах бөгөөд тэдгээр ажиллагсад нь тохиромжтой этгээд мөн болох тухай болон ур чадвар, туршлагын талаарх тодорхойлолт;

2.6.15. үүсгэн байгуулах хамтын хөрөнгө оруулалтын сангийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр ажиллуулахаар төлөвлөж байгаа этгээд нь тохиромжтой этгээд мөн болох болон тэдгээрийн ур чадвар, туршлагын талаарх дэлгэрэнгүй тодорхойлолт;

2.6.16. Хорооноос тогтоосон бусад мэдээлэл.

2.7. Энэхүү журмын 2.6-д заасан баримт бичгийн төсөл нь тухайн баримт бичгийг батлах, эсхүл гэрээг байгуулах бэлтгэлийг хангасан төслийн эцсийн хувилбар байна.

2.8. Хороо нь энэхүү журмын 2.5-2.6-д заасан хүсэлтийг хянан шийдвэрлэх явцад шаардагатай гэж үзсэн өөр бусад мэдээлэл, бичиг баримтыг хүсэлт гаргагчаас шаардан гаргуулах, үйл ажиллагаатай нь танилцах бүрэн эрхтэй.

2.9. Хороо хамтын хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах бичиг баримтыг бүртгүүлэх хүсэлтийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор бүртгэх эсэх шийдвэрийг гаргах бөгөөд хугацааг хүсэлтэд тусгах болон түүнд хавсарган ирүүлэх баримт бичгийн бүрдэл бүрэн хангагдсан өдрөөс эхлэн тооцно.

2.10. Хороо энэхүү журмын 2.9-д заасан шийдвэрийн талаар хүсэлт гаргагчид бичгээр мэдэгдэнэ.

2.11. Хороо нь үүсгэн байгуулах бичиг баримтыг бүртгэхээр шийдвэрлэсэн эсхүл бүртгэхээс татгалзах шийдвэрийг Хорооны хурлаас гаргах бөгөөд уг шийдвэрийн талаар хүсэлт гаргагчид бичгээр мэдэгдэнэ.

2.12. Хороо энэхүү журмын 2.11-д заасны дагуу хамтын хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах бичиг баримтыг бүртгэхээс татгалзвал хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах ажиллагааг дуусгавар болно.

2.13. Хүсэлт гаргагч хөрөнгө оруулалтын менежментийн компани нь бичгээр хүсэлт гаргасан нөхцөлд Хорооноос хамтын хөрөнгө оруулалтын сан үүсгэн байгуулах бичиг баримтыг бүртгэхээс татгалзсан талаарх тайлбарыг хүсэлт гаргагчид өгч болно.

2.14. Хороо хамтын хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах бичиг баримтыг бүртгэх нь тухайн бичиг баримтын агуулга, түүний дагуу үүсгэн байгуулах хамтын хөрөнгө оруулалтын сан болон үүсгэн байгуулах хамтын сангийн үйл ажиллагааг гүйцэтгэх хөрөнгө оруулалтын менежментийн компани, түүний ажилтан, удирдлагын талаар ямар нэг баталгаа гаргасан гэж үзэх үндэслэл болохгүй ба тэдгээртэй холбоотой аливаа эрсдэл, алдагдал, хохирлыг Хороо хариуцахгүй.

2.15. Хороо хамтын хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах бичиг баримтыг бүртгэсэн эсэхээс үл хамаарч хөрөнгө оруулагч болон хамтран ажиллах аливаа иргэн, хуулийн этгээд нь хөрөнгө оруулалтын шийдвэрээ бие даан гаргаж өөрийн гаргасан шийдвэртэй холбоотой үүсэх аливаа үр дагаварыг өөрсдөө хариуцна.

Гурав. Хамтын хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах

3.1. Энэхүү журмын 1.5.2-1.5.6-д заасан ажиллагааг хамтын хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах бичиг баримтыг Хороонд бүртгүүлснээс хойш нэг сарын хугацаанд гүйцэтгэн хамтын хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн танилцуулгыг Хороонд бүртгүүлэх хүсэлтийг гаргана.

3.2. Энэхүү журмын 3.1-д заасан хугацаанд үүсгэн байгуулагч хөрөнгө оруулалтын менежментийн компани нь нэгж эрхийн танилцуулгыг Хороонд бүртгүүлэх хүсэлт гаргаагүй тохиолдолд тухайн хамтын хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах ажиллагааг дуусгавар болгоно.

3.3. Хамтын хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах бичиг баримтыг Хороонд бүртгүүлсний дараа тухайн санг үүсгэн байгуулах ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байгаа хөрөнгө оруулалтын менежментийн компани нь хамтын хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах хурлыг зарлан хуралдуулна.

3.4. Хамтын хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах хурлыг зарлан хуралдуулах ажиллагааг Компанийн тухай хуульд заасан журмын дагуу зохион байгуулна.

3.5. Хамтын хөрөнгө оруулалтын санг нэгээс дээш тооны хөрөнгө оруулалтын менежментийн компани үүсгэн байгуулах тохиолдолд тэдгээр нь хоорондоо үүсгэн байгуулагчдын гэрээг байгуулна.

3.6. Хамтын хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах хурлаар сан үүсгэн байгуулах шийдвэрээс гадна сангийн дүрмийг баталж төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох ба энэхүү журмын 5, 6 дугаар зүйлд заасан гэрээний төслүүдийг байгуулах эсэх шийдвэрийг гаргана.

3.7. Хамтын хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах хурлаар үүсгэн байгуулагч хөрөнгө оруулалтын менежментийн компаниас тухайн хөрөнгө оруулалтын санд оруулах хөрөнгийг тодорхойлох бөгөөд уг хөрөнгийг тусгайлсан дансанд бэлнээр байршуулсны үндсэн

дээр холбогдох нэгж эрхийг хөрөнгө оруулалтын менежментийн компанийн эзэмшилд шилжүүлэн бүртгэж болно.

3.8. Энэхүү журмын 3.7-д зааснаас бусад тохиолдолд хамтын хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн танилцуулгыг Хороонд бүртгүүлэхээс өмнө тухайн хамтын хөрөнгө оруулалтын санд бусдаас хөрөнгө оруулалт татах, уг сангийн нэгж эрхийг бусдад худалдах болон тухайн хамтын хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулагч хөрөнгө оруулалтын менежментийн компани нь өөрийн эзэмшилд бүртгүүлсэн нэгж эрхийг бусдад худалдах, шилжүүлэхийг хориглоно.

3.9. Энэхүү журмын 3.7-д заасан үүсгэн байгуулагч хөрөнгө оруулалтын менежментийн компанид худалдах сангийн нэгж эрхийн үнэ нь тухайн хамтын хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийг нийтэд санал болгон худалдах үнээс багагүй байна.

3.10. Энэхүү журмын 3.6-д заасан хамтын хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах шийдвэрийг гарган сангийн дүрмийг баталсны үндсэн дээр тухайн санг хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлэх ба хүсэлтийг үүсгэн байгуулагч хөрөнгө оруулалтын менежментийн компани эсхүл тухайн сангийн үүсгэн байгуулах хурлаас томилсон этгээд гаргана.

3.11. Хамтын хөрөнгө оруулалтын сангийн нэр нь Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 15.1-д заасны дагуу түүний оноосон нэр болон “хамтын хөрөнгө оруулалтын сан” гэсэн дэлгэрэнгүй тэмдэглэгээ, эсхүл “Хамтын ХОС” гэсэн товчилсон тэмдэглэгээнээс бүрдэнэ.

3.12. Хамтын хөрөнгө оруулалтын сангийн оноосон нэр нь дараах шаардлагыг хангасан байна:

3.12.1. тухайн хамтын хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны чиглэлтэй нийцсэн байх;

3.12.2. хамтын хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгө оруулалтын бодлого, танилцуулгад заасан мэдээллийн агуулгатай зөрчилдөөгүй байх;

3.12.3. хамтын хөрөнгө оруулалтын санд хөрөнгө оруулах нь нэгж эрх эзэмшигчид эрсдэлгүй байх, эсхүл хэт өндөр буюу бодит бус өгөөжтэй байх зэрэг үндэслэлгүй, буруу, ташаа ойлголтыг нэгж эрх эзэмшсэн эсхүл эзэмших иргэн, хуулийн этгээдэд төрүүлэхгүй байх;

3.12.4. Монгол Улс болон өөр бусад орны хөрөнгө оруулалтын сангийн нэртэй давхардаагүй байх;

3.12.5. нийтээр хүлээн зөвшөөрсөн ёс суртахууны хэм хэмжээнд харшлаагүй байх.

3.13. Хамтын хөрөнгө оруулалтын санг хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгэсний дараа тухайн хамтын хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн танилцуулгыг эцэслэн боловсруулж, уг танилцуулгыг тухайн хамтын хөрөнгө оруулалтын сангийн үүсгэн байгуулагч эсхүл бусад эрх бүхий этгээд Хороонд бүртгүүлэхээр хүргүүлнэ.

Дөрөв. Хамтын хөрөнгө оруулалтын сангийн дүрэм, хөрөнгө оруулалтын бодлогын бичиг баримт

4.1. Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 16.1, Компанийн тухай хуулийн 16 дугаар зүйлд заасны дагуу хамтын хөрөнгө оруулалтын сангийн дүрэмд дараах зүйлийг тусгана:

- 4.1.1. хамтын хөрөнгө оруулалтын сангийн бүрэн болон товчилсон оноосон нэр, түүний хэлбэрийг тодорхойлсон товчилсон ялгах тэмдэглэгээ;
- 4.1.2. хамтын хөрөнгө оруулалтын сангийн зарласан болон гаргасан нэгж эрхийн тоо, тэдгээрийн төрөл, нэрлэсэн үнэ, нэгж эрх бүрд хамаарах нэгж эрх эзэмшигчийн эрх, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ;
- 4.1.3. аливаа төрлийн нэгж эрхийг арилжих журам, тодорхой төрлийн нэгж эрхийг гаргахад мөрдөх хязгаарлалт;
- 4.1.4. хамтын хөрөнгө оруулалтын сангийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн тоо;
- 4.1.5. хамтын хөрөнгө оруулалтын сангийн эрх барих дээд байгууллага болох нэгж эрх эзэмшигчдийн хурал, төлөөлөн удирдах зөвлөлийн хууль дүрмээр тодорхойлсон бүрэн эрх, тэдгээрийг хэрэгжүүлэхтэй холбоотой зохицуулалт, эрх хэмжээний хязгаарлалт;
- 4.1.6. хамтын хөрөнгө оруулалтын сангийн дотоод хяналтын бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагааны журам;
- 4.1.7. хамтын хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааны чиглэл, хамтын хөрөнгө оруулалтын сан нь зөвхөн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхлэх зорилготой байх тухай, хөрөнгө оруулалтын зорилтуудтай холбоотой мэдээлэл, үүнд хөрөнгө оруулалтын эрсдлийг тараан байршуулах, хөрөнгө оруулах хөрөнгийн төрөл болон хөрөнгө оруулалт, зээл, үнэт цаасны зээлийн хязгаарлалт, түүнтэй холбоотой дэлгэрэнгүй мэдээлэл, эсвэл тийм хязгаарлалтгүй бол шалтгаан, үндэслэл;
- 4.1.8. хамтын хөрөнгө оруулалтын сангийн төрөл, хэлбэр;
- 4.1.9. хөрөнгө оруулалтын менежментийн компанийн нэр, оршин байгаа газрын хаяг;
- 4.1.10. кастодианы үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийн нэр, хуулийн этгээдийн улсын бүртгэл, оршин байгаа газрын хаяг;
- 4.1.11. хамтын хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа явуулах хугацаа;
- 4.1.12. хамтын хөрөнгө оруулалтын санд төвлөрүүлэх хөрөнгийн нийт хэмжээ;
- 4.1.13. хамтын хөрөнгө оруулалтын сангийн орлого, түүний хувиарлалтын журам;
- 4.1.14. хамтын хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа эрхлэх хугацаа дуусгавар болж хөрөнгийг хөрөнгө оруулагчдад бүрэн хуваарилж дууссан тохиолдолд татан буугдах тухай болон татан буулгах ажиллагааны журам;
- 4.1.15. хамтын хөрөнгө оруулалтын сангийн зардлын төрөл, хэмжээ, тэдгээрийг зарлагдах журам;
- 4.1.16. хамтын хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх эзэмшигч нь тухайн сангийн өр төлбөр, бусдаас авсан зээлийг өөрийн хөрөнгөөр хариуцахгүй тухай;
- 4.1.17. нэгж эрх эзэмшигч өөрийн нэгж эрхийн төлбөрийг төлсний дараа аливаа төлбөр хийх үүрэг хүлээхгүй тухай;

4.1.18. хамтын хөрөнгө оруулалтын сангийн эрх бүхий албан тушаалтны үүрэг, хариуцлага;

4.1.19. хамтын хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааг түр зогсоох болон татан буулгах үндэслэл, энэ тохиолдолд нэгж эрх эзэмшигчийн эдлэх эрх, хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгийг үнэлэх тодорхойлох аргачлал;

4.1.20. хамтын хөрөнгө оруулалтын сангийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах журам;

4.1.21. бусад.

4.2. Хамтын хөрөнгө оруулалтын сангийн дүрэмд хамтын хөрөнгө оруулалтын сангийн төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, сангийн менежер болон хуулийн дагуу нэгж эрх эзэмшигчийн хүлээхээр заасан хариуцлагаас чөлөөлөх тухай заалт тусгахыг хориглох бөгөөд хэрэв тусгасан бол тэдгээр нь хүчингүй байна.

4.3. Хамтын хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичигт Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 17.1-д заасан зүйлийг заавал тусгасан байна.

Тав. Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээг байгуулах

5.1. Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 47 дугаар зүйлд заасны дагуу хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээний хугацаа нь тухайн хөрөнгө оруулалтын сангийн дүрэмд заасан сангийн үйл ажиллагаа эрхлэх хугацаатай нэгэн адил байна.

5.2. Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ нь Хорооны 2014 оны 08 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн болон үйл ажиллагааны журам”-ын 6 дугаар зүйлд заасан шалгуур, шаардлагыг хангасан байна.

5.3. Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээнд Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 47.2-т заасан үүргийг тусгах ба хуульд заасан үүрэг, хариуцлагыг бууруулах эхсүл чөлөөлөх агуулга бүхий заалт тусгахыг хориглоно.

5.4. Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 46.8-д заасны дагуу үүсгэн байгуулагч хөрөнгө оруулалтын менежментийн компани нь үйлчилгээ үзүүлж байгаа хамтын хөрөнгө оруулалтын сантай байгуулсан гэрээний үүргээ зөрчсөний улмаас тухайн санд учруулсан хохирлыг хариуцахгүй тухай аливаа заалт хөрөнгө итгэмжэн удирдах гэрээнд тусгахыг хориглох бөгөөд тусгасан тохиолдолд тэдгээр заалт нь хүчин төгөлдөр бус байна.

Зургаа. Хөрөнгө хадгалах гэрээ байгуулах

6.1. Хамтын хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгийг хадгалахтай холбоотой кастодиантай байгуулах хөрөнгө хадгалах гэрээний хугацаа нь тухайн хамтын хөрөнгө оруулалтын сангийн дүрэмд заасан сангийн үйл ажиллагаа эрхлэх хугацаатай нэгэн адил байна.

6.2. Хөрөнгө хадгалах гэрээ нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 46.5-д заасан Хороо болон Монголбанкнаас тогтоосон кастодианы үйл ажиллагааны журмаар тогтоосон шаардлагыг хангасан байна.

6.3. Хөрөнгө хадгалах гэрээнд Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 50 дугаар зүйлд заасан зүйлийг заавал тусгана.

6.4. Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 50.2-т заасны дагуу хөрөнгө хадгалах гэрээнд хууль болон сангийн дүрмээр хөрөнгө оруулалтын менежментийн компани болон кастодианы хүлээхээр заасан үүрэг, хариуцлагыг бууруулах, чөлөөлөх тухай заалт тусгахыг хориглох бөгөөд хэрэв тусгасан бол тэдгээр заалт нь хүчингүй байна.

Долоо. Хамтын хөрөнгө оруулалтын сангийн танилцуулга, түүнийг бүртгүүлэх

7.1. Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 19.11-д заасны дагуу хамтын хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн танилцуулгад дор дурдсан мэдээллийг тусгана:

7.1.1. хамтын хөрөнгө оруулалтын сангийн оноосон нэр, оршин байгаа газрын шуудангийн болон холбоо барих хаяг, эрхлэх хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа, хөрөнгийн биржид бүртгүүлэх эсэх тухай;

7.1.2. нэгж эрх гаргагч хамтын хөрөнгө оруулалтын сангийн хуулийн этгээдийн улсын бүртгэлийн болон регистрийн дугаар, бүртгэсэн он, сар, өдөр;

7.1.3. нэгж эрх гаргагч хамтын хөрөнгө оруулалтын сангийн 5 болон түүнээс дээш хувийн нэгж эрх эзэмшигч хуулийн этгээдийн оноосон нэр, улсын бүртгэлийн дугаар;

7.1.4. дангаар болон холбогдох этгээдийн хамт эзэмшиж байгаа нэгж эрхийн тоо, хувь хэмжээ;

7.1.5. нэгж эрх гаргагч хамтын хөрөнгө оруулалтын сангийн бүтэц, зохион байгуулалт, эрх бүхий албан тушаалтны талаарх мэдээлэл, тэдгээрийн өмчлөл дэх нэгж эрхийн тоо, хувь хэмжээний талаарх мэдээлэл;

7.1.6. нэгж эрх гаргагчийн хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн гэрээ, хэлцэл, тэдгээрийн хэрэгжилтийн тухай;

7.1.7. хамтын хөрөнгө оруулалтын сангийн холбогдох этгээдийн тухай;

7.1.8. нийтэд санал болгож байгаа нэгж эрхийн тоо, хэлбэр, нэрлэсэн үнэ, тэдгээрийг нийтэд санал болгох болон арилжих болон ногдол ашиг хуваарилах нөхцөл, журам;

7.1.9. нийтэд санал болгож байгаа нэгж эрхээр гэрчлэгдэх эрх, үүрэг;

7.1.10. хамтын хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаанд учирч болох эрсдэл, эрсдэлийн удирдлагын төлөвлөгөө;

7.1.11. тухайн нэгж эрхийг нийтэд санал болгох ажиллагаанд хамтран оролцож байгаа энэхүү журмын 7.1.15, 7.1.16-д зааснаас бусад зохицуулалттай этгээд болон бусад мэргэжлийн үйлчилгээ үзүүлж байгаа этгээдийн тухай, тэдгээртэй байгуулсан гэрээгээр хүлээсэн эрх, үүрэг, хариуцлагын тухай;

7.1.12. хөрөнгө оруулалтын сангийн дүрэм;

7.1.13. хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичиг;

7.1.14. хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа явуулах хугацаа;

7.1.15. хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулагч хөрөнгө оруулалтын менежментийн компанийн мэдээлэл, тус компанитай байгуулсан хөрөнгө оруулалтын менежментийн үйлчилгээ үзүүлэх гэрээний хуулбар, гэрээгээр хүлээсэн эрх, үүрэг, хариуцлагын тухай, үйлчилгээний урамшуулал болон зардлын тооцоолол болон хөрөнгө итгэмжлэн удирдах ажиллагааг гүйцэтгэх менежерийн талаарх мэдээлэл;

7.1.16. кастодианы үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийн мэдээлэл, кастодиантай байгуулсан хөрөнгө хадгалах гэрээний хуулбар, гэрээгээр хүлээсэн эрх, үүрэг, хариуцлагын тухай, үйлчилгээний хөлсний хэмжээ, тооцоолол;

7.1.17. хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа явуулахтай холбоотой гарах бусад зардлын тооцоолол;

7.1.18. хамтын хөрөнгө оруулалтын сан төлбөрийн чадваргүй болох, алдагдал хүлээх тохиолдолд авч хэрэгжүүлэх арга хэмжээ, үйл ажиллагааны журам;

7.1.19. нэгж эрх эзэмшигчдэд өгөх мэдээлэл, санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан гаргах, тайланг нэгж эрх эзэмшигчдэд хүргэх журам болон нэгж эрх эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах бусад зохицуулалт;

7.1.20. Хорооноос тогтоосон бусад мэдээлэл.

7.2. Хамтын хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн танилцуулгад дараах баримт бичгийг хавсаргана:

7.2.1. хамтын хөрөнгө оруулалтын сангийн хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатаар баталгаажуулсан хуулбар;

7.2.2. энэхүү журмын 2.5, 2.6-д заасан төсөл хэлбэрээр Хороонд бүртгүүлсэн баримт бичгийн батлагдсан эсхүл байгуулсан баримт бичгийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;

7.2.2. энэхүү журмын 2.5, 2.6-д заасан төсөл хэлбэрээр Хороонд бүртгүүлсэн баримт бичгийн өөрчлөлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, холбогдох өөрчлөлтийн үндэслэлийн талаарх тайлбар;

7.2.3. энэхүү журмын 2.5 болон 2.6-д заасан хамтын хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаанд хамаарах эрх бүхий албан тушаалтан, мэргэжилтэн өөрчлөгдсөн эсэх, тэдгээр нь тохиромжтой этгээд мөн болох тухай болон ур чадвар, туршлагын талаарх дэлгэрэнгүй тодорхойлолт;

7.2.4. нэгж эрхийн танилцуулгыг боловруулахад оролцсон иргэн, хуулийн этгээдийн жагсаалт, тэдгээрийн үйлдсэн судалгаа, тайлан, дүгнэлт.

7.3. Хамтын хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн танилцуулгыг Хороо хүсэлт хүлээн авснаас хойш ажлын 15 хоногийн дотор бүртгэх эсэхийг шийдвэрлэнэ. Энэхүү хугацааг бүрдэл бүрэн хангагдсан өдрөөс эхлэн тооцно.

7.4. Хороо нэгж эрхийн танилцуулгыг бүртгэх эсэх шийдвэр гаргахдаа Үнэт цаасны зах зээлийн тухай болон Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль тогтоомжийг үндэслэл болгоно.

7.5. Хамтын хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн танилцуулгыг Хороо бүртгэснээр тухайн нэгж эрхийн танилцуулгыг нийтэд танилцуулж болно.

7.6. Хамтын хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн танилцуулгыг Хороо бүртгэхээс татгалзсан тохиолдолд уг танилцуулгыг нийтэд танилцуулах, уг баримт бичигт үндэслэн бусдаас хөрөнгө татан төвлөрүүлэхийг хориглоно.

7.7. Хороо нь хамтын хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн танилцуулгыг бүртгэхээс татгалзсан тохиолдолд уг шийдвэрийг гарсанаас хойш нэг сарын дотор тухайн санг татан буулгах ажиллагааг үүсгэн байгуулагч хөрөнгө оруулалтын менежментийн компани гүйцэтгэнэ.

7.8. Хороо хамтын хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн танилцуулгыг бүртгэх хүсэлтийг шийдвэрлэх явцад шаардлагатай мэдээлэл, бичиг баримтыг хүсэлт гаргагчаас болон тухайн санд холбогдох үйлчилгээг үзүүлэхээр гэрээ байгуулсан буюу үйлчилгээ үзүүлсэн иргэн, хуулийн этгээдээс шаардах, шаардлагатай тохиолдолд шалгалт явуулж болно.

Найм. Хамтын хөрөнгө оруулалтын сангийн танилцуулгыг нийтэд танилцуулах, хөрөнгө татан төвлөрүүлэх

8.1. Хамтын хөрөнгө оруулалтын сан нь нийтээс хөрөнгө оруулалт татах ажиллагааг сангийн нэгж эрхийн танилцуулгад үндэслэн хэрэгжүүлэх бөгөөд хамтын хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн танилцуулгыг нийтэд танилцуулах, хөрөнгө төвлөрүүлэхэд энэхүү журмыг баримтална.

8.2. Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 19.2-т заасны дагуу хамтын хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулагч хөрөнгө оруулалтын менежментийн компани нь тухайн санд хөрөнгө оруулалтын менежментийн үйлчилгээ үзүүлж болно.

8.3. Хамтын хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийг нийтэд санал болгох ажиллагааг гүйцэтгэхдээ нэгж эрхийн танилцуулгыг сонирхогч этгээд үнэ төлбөргүйгээр танилцах боломжийг бүрдүүлнэ.

8.4. Хороо нь хамтын хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн танилцуулгыг нийтэд танилцуулах ажиллагааны явцад хяналт, шалгалт хийх эрхтэй бөгөөд хөрөнгө оруулагчдын эрх ашигт сөргөөр нөлөөлөх буюу дутуу, худал, төөрөгдүүлэх, худал амлалт өгөх зэрэг нөхцөл байдал үүссэн нөхцөлд нэгж эрхийн танилцуулгыг нийтэд танилцуулах ажиллагааг зогсоох буюу нэгж эрхийн танилцуулгын бүртгэлийг хүчингүй болгох арга хэмжээ авч болно.

8.5. Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 19.4-т заасны дагуу хамтын хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийг анхдагч зах зээлд худалдах арилжааг үнэт цаасны арилжаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдэд бүртгүүлэх замаар зохион байгуулж болно. Энэ тохиолдолд холбогдох үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагын дүрэм, журам, шаардлагад нийцүүлэн нэгж эрхийн танилцуулгыг нийтэд танилцуулах ажиллагааг гүйцэтгэнэ.

8.6. Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 19.5-д заасны дагуу хамтын хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн танилцуулгыг Хороонд бүртгүүлснээс хойш зургаан сар хүртэлх хугацаанд нийтэд танилцуулах бөгөөд энэ хугацаанд сангийн дүрэмд заасан хөрөнгийг төвлөрүүлж чадаагүй нөхцөлд тухайн сангийн үүсгэн байгуулах ажиллагааг зогсоож, уг санд сангийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгохгүй.

8.7. Хамтын хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийг анхдагч зах зээлд зөвхөн мөнгөн хөрөнгөөр худалдах ба дараах хэлбэрээр хөрөнгө төвлөрүүлэхийг хамтын хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах зорилгоор нийтээс хөрөнгө татан төвлөрүүлсэн гэж үзэхгүй:

- 8.7.1. хөрөнгө оруулалтын бус зорилгоор буюу хадгаламж эсхүл харилцах дансны нөхцлөөр хөрөнгө төвлөрүүлсэн;
- 8.7.2. нийтийн хэрэглээний зориулалт бүхий дансанд хөрөнгө байршуулах буюу тухайн хамтын хөрөнгө оруулалтын сангаас өөр бусад хөрөнгө оруулагчид захиран зарцуулах эрхтэй байх нөхцлөөр хөрөнгө төвлөрүүлсэн;
- 8.7.3. өрийн бичиг, вексель, опцион зэрэг нэгж эрхээс бусад төрлийн үнэт цаас гаргах замаар хөрөнгө төвлөрүүлсэн;
- 8.7.4. нэгж эрх худалдахаас бусад хэлбэрээр төвлөрүүлсэн.
- 8.8. Хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийг анхдагч зах зээлд зээлээр буюу төлбөрийг дараа хийх нөхцлөөр худалдах, эсхүл төлбөргүйгээр бусдад шилжүүлэхийг хориглох ба төлбөр хийгдсэний дараа нэгж эрхийг шилжүүлэх нөхцлөөр худалдана.
- 8.9. Хамтын хөрөнгө оруулалтын сан нь нэгж эрхээ анхдагч зах зээлд худалдах ажиллагааг энэхүү журмын 8.6-д заасан хугацаанд дуусгавар болгож нэгж эрхийг анхдагч зах зээлд худалдах ажиллагааны тайланг ажлын 3 хоногт багтаан гаргаж уг тайланг хөрөнгө оруулагч болон Хороонд танилцуулах үүрэгтэй.
- 8.10. Хамтын хөрөнгө оруулалтын сан нь дүрэмд заасан хөрөнгөө нийтээс төвлөрүүлж чадсан нөхцөлд энэхүү журмын 8.9-д заасан тайланг гарган Хороонд хүргүүлэх ба хамтын хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авах хүсэлтээ хамт гаргана.
- 8.11. Хамтын хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийг анхдагч зах зээлд худалдах ажиллагааны тайланг Хороо хянасны үндсэн дээр уг ажиллагаа амжилттай болсон эсэхийг шийдвэрлэх бөгөөд уг шийдвэрийг тухайн санд хамтын хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох шийдвэртэй хамт гаргана.
- 8.12. Хороо хамтын хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олгохоос татгалзах шийдвэр гаргах нь уг сангийн нэгж эрхийг анхдагч зах зээлд худалдах ажиллагааг амжилттай болсонд тооцохоос татгалзах үндэслэл болно.
- 8.13. Хороо нэгж эрхийг андагч зах зээлд амжилттай болсонд тооцсон нөхцөлд тухайн хамтын хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлж болно.
- 8.14. Энэхүү журмын 8.11-д заасны дагуу Хороо хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийг анхдагч зах зээлд худалдах ажиллагааг амжилттай болсонд тооцсоноор уг нэгж эрхийг худалдах, худалдан авах хэлцлийг хүчингүй болгохгүй.
- 8.15. Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 19.6-д заасан хугацаанд шаардлагатай хөрөнгө оруулалтыг төвлөрүүлж чадаагүй тохиолдолд үүсгэн байгуулагч хөрөнгө оруулалтын менежментийн компани нь энэ тухай Хороонд мэдэгдэх үүрэг хүлээнэ.
- 8.16. Хороо нь энэхүү журмын 8.15-д заасан мэдэгдлийг хүлээн авч тухайн хамтын хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах ажиллагааг зогсоох тухай шийдвэр гаргах бөгөөд уг шийдвэр гарснаас хойш ажлын 15 өдөрт багтаан тухайн сан нь өөрийн дансанд хуримтлагдсан хөрөнгийг хөрөнгө оруулагчид буцаан олгох, бүртгэлээс хасуулж, татан буулгах ажиллагааг зохион байгуулна.

8.17. Хамтын хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн төлбөрийг тухайн сан болон түүнд үйлчилгээ үзүүлж байгаа хөрөнгө оруулалтын менежментийн компанийн данснаас өөр дансанд байршуулах бөгөөд Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 19.8-д заасны дагуу Хорооноос хамтын хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох хүртэлх хугацаанд тухайн сангийн дансанд байршуулсан буюу сангийн нэгж эрх худалдан авахаар төлсөн мөнгөн хөрөнгийг зарцуулах эрх тухайн сан болон хөрөнгө оруулалтын менежментийн компанид нээгдэхгүй.

Ес. Хамтын хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох

9.1. Хамтын хөрөнгө оруулалтын сан нь энэхүү журмын 8.10-т заасан хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авах хүсэлтэд Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 27.2-т заасан баримт бичгээс гадна дараах бичиг баримтыг хавсаргана:

9.1.1. хамтын хөрөнгө оруулалтын сангийн дүрэмд заасан хөрөнгийг төвлөрүүлсэн тухай хөрөнгө хадгалах гэрээ байгуулсан кастодианы тодорхойлолт;

9.1.2. хамтын хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааг эхлүүлэх бэлтгэлийг хангасан болохыг илэрхийлэх баримт бичиг;

9.1.3. бусад.

9.2. Хороо нь хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 15 хоногийн дотор хамтын хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох эсэх асуудлыг шийдвэрлэнэ.

9.3. Хороо нь дор дурдсан нөхцөл шаардлага хангагдсан нөхцөлд хамтын хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоно:

9.3.1. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 28.1-д заасан нөхцөл шаардлагыг хангасан;

9.3.2. хамтын хөрөнгө оруулалтын сангийн дүрэмд заасан хөрөнгийг тусгаарласан дансанд бүрэн төвлөрүүлсэн;

9.3.3. хамтын хөрөнгө оруулалтын санд үйлчилгээ үзүүлэх хөрөнгө оруулалтын менежментийн компани, кастодиан болон үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай үйл ажиллагаа эрхэлж байгаа хуулийн этгээд, мэргэжилтэн нь тохиромжтой этгээдийн болон тухайн үйл ажиллагаагаа эрхлэх нөхцөл, шаардлагыг хангаж байгаа;

9.3.4. хөрөнгө оруулагчдын эрх ашигт сөргөөр нөлөөлж болох буюу тусгай зөвшөөрөл олгохоос татгалзах өөр бусад үндэслэлгүй;

9.4. Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 19.9-д заасны дагуу Хороо хамтын хөрөнгө оруулалтын санг байгуулагдсанд тооцож хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосноор сангийн үйл ажиллагаа эрхлэх бөгөөд уг өдрөөс хөрөнгө оруулалтын менежментийн компани хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэх эрх нээгдэнэ.

9.5. Хамтын хөрөнгө оруулалтын санд олгох хамтын хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хүчинтэй байх хугацаа нь тухайн сангийн дүрэмд заасан үйл ажиллагаа эрхлэх хугацаатай адил байна.

9.6. Хамтын хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа эрхлэхэд дараах нөхцөл, шаардлагыг хангаж ажиллана:

9.6.1. Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль, Хороо болон бусад эрх бүхий төрийн байгууллага, албан тушаалтны баталсан дүрэм, журмыг дагаж мөрдөх, үйл ажиллагаагаа хуулийн хүрээнд явуулах;

9.6.2. тохиромжтой этгээдийн шаардлагыг хангаж ажиллах;

9.6.3. хөрөнгө оруулалтын бодлогын бичиг баримт, дүрэм, нэгж эрхийн танилцуулгад заасан хязгаарын хүрээнд үйл ажиллагаагаа явуулах;

9.6.4. хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хүндэтгэн тэргүүн ээлжинд ханган ажиллах;

9.6.5. мэргэжлийн, хөрөнгө, техникийн болон бусад нөхцөл шаардлага, шалгуурыг хангаж ажиллах.

9.7. Хамтын хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосноос хойш ажлын 5 хоногийн дотор холбогдох бүртгэлийг хуулийн этгээдийн улсын бүртгэлийн албанд бүртгүүлнэ.

9.8. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 29.1-д заасан үндэслэл тогтоогдсон нөхцөлд Хороо хамтын хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлж болно.

9.9. Хамтын хөрөнгө оруулалтын сангийн удирдлага, эсхүл хөрөнгө итгэмжлэн удирдах үйлчилгээ үзүүлж байгаа хөрөнгө оруулалтын менежментийн компани нь дараах нөхцөл байдал үүссэн нөхцөлд хамтын хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааг түдгэлзүүлж нэгж эрх эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах арга хэмжээ авах бөгөөд энэ тухай Хороонд тухай бүр мэдэгдэх үүрэгтэй:

9.9.1. хамтын хөрөнгө оруулалтын сангийн удирдлагын эрх бүхий албан тушаалтан, үйлчилгээ үзүүлж байгаа хөрөнгө оруулалтын менежментийн компани, кастодиан нь тохиромжтой этгээдийн шаардлагыг хангахгүй болсон;

9.9.2. хамтын хөрөнгө оруулалтын санг татан буулгах нөхцөл байдал үүссэн;

9.9.3. нэгж эрх эзэмшигчдийн хурлыг заавал зарлан хуралдуулах нөхцөл байдал үүссэн;

9.9.4. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 29.1-д заасан нөхцөл байдал бий болсон.

9.10. Хамтын хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх үндэслэл арилсан буюу үйл ажиллагааг сэргээх боломжтой гэж Хороо үзсэн нөхцөлд тусгай зөвшөөрлийг сэргээх бөгөөд энэ тохиолдолд тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацаа өөрчлөгдөхгүй, сунгахгүй.

9.11. Хороо дор дурдсан үндэслэлээр хамтын хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож болно:

9.11.1. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 38.6-д заасан нөхцөл байдал үүссэн;

9.11.2. Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 19.13-т заасан нөхцөл байдал үүссэн;

9.11.3. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 38.6-д заасан хориглох үйл ажиллагааг эрхэлсэн;

9.11.4. хууль тогтоомжид заасан бусад үндэслэл.

9.12. Хамтын хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох нь тухайн санг татан буулгах үндэслэл болох бөгөөд энэ тохиолдолд хөрөнгө оруулалтын менежментийн компани эсхүл тухайн сангийн төлөөлөн удирдах зөвлөл, эсхүл гүйцэтгэх захирал нь нэгж эрх эзэмшигчдийн ээлжит бус хурлыг ажлын 15 хоногийн дотор зарлан хуралдуулж хамтын хөрөнгө оруулалтын санг татан буулгах ажиллагааг гүйцэтгэнэ.

9.13. Хороо нь хамтын хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, сэргээх болон хүчингүй болгох тухай шийдвэрийг өөрийн цахим хуудсанд байршуулах замаар нийтэд мэдээлнэ.

Арав. Бусад

10.1. Хороо нь үүсгэн байгуулах ажиллагааны явцад хяналт тавих, хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах ажиллагаанд оролцож байгаа иргэн, хуулийн этгээдэд шаардлага, даалгавар өгөх, тэдгээрийн биелэлтийг хангуулах бүрэн эрхтэй байна.

10.2. Хамтын хөрөнгө оруулалтын сан үүсгэн байгуулагч хөрөнгө оруулалтын менежментийн компани, түүний эрх бүхий албан тушаалтан, ажилтан болон уг ажиллагаанд оролцож байгаа иргэн, хуулийн этгээд, тэдгээрийн ажилтан нь Хорооны зүгээс тавих хяналтад аливаа хэлбэрээр саад хийхийг хориглоно.

10.3. Хороо нь даалгавар өгөх ажиллагааг Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 56 дугаар зүйлд нийцүүлэн хэрэгжүүлнэ.

10.4. Хамтын хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах ажиллагааг эрхлэн гүйцэтгэгч нь хамтын хөрөнгө оруулалтын сан үүсгэн байгуулах ажиллагааны явц, гүйцэтгэлийн талаар Хороонд мэдээлэл өгөх үүрэгтэй бөгөөд мэдээллийн төрөл, агуулга, хүрээний талаар Хороо тухай бүр чиглэл өгч ажиллана.

10.5. Хамтын хөрөнгө оруулалтын сан үүсгэн байгуулах бичиг баримтыг Хороонд бүртгүүлснээс хойш үүсгэн байгуулах ажиллагааг зогсоосон, цуцалсан эсхүл уг үүсгэн байгуулах ажиллагааг хэрэгжүүлэх хугацааг хууль болон энэ журамд заасан хугацааны дотор сунгах хүсэлтэй бол тухайн хамтын хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байгаа хөрөнгө оруулалтын менежментийн компани нь энэ талаар тухай бүр ажлын 5 хоногийн дотор Хороонд мэдэгдэх үүрэгтэй. Ингэхдээ уг мэдэгдэлд үүсгэн байгуулах ажиллагааг зогсоох, цуцлах, хойшлуулах тухай шийдвэрийн үндэслэлийг дурдсан байна.

10.6. Хамтын хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байгаа хөрөнгө оруулалтын менежментийн компани, түүний эрх бүхий албан тушаалтан, ажилтанд Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 14.6, 44.5, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 38.6, 38.7, 38.8, 40.4 болон холбогдох хууль, тогтоомж болон Хорооноос баталсан бусад журамд заасан хориглох зохицуулалт нэг адил хамаарна.

10.7. Хороо нь хамтын хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах ажиллагаанд оролцогч иргэн хуулийн этгээдэд Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 57 дугаар зүйлд заасан захиргааны шийтгэл ногдуулж болно.

10.8. Хөрөнгө оруулалтын менежментийн компани нь хамтын хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах ажиллагааг эрхлэн гүйцэтгэх явцдаа санаатай, эсхүл болгоомжгүй үйлдлийн улмаас бусдад учруулсан хохирлыг болон үүсгэн байгуулж байгаа хамтын хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгө оруулалтын бодлогыг зөрчсөний улмаас тухайн санд учруулсан алдагдлыг тус тус өөрийн хөрөнгөөр хариуцна.

---oOo---